



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2006 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 530

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр 2 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн 2006 оны 108 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Улаанбаатар" чуулгын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц орон тооны хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. "Улаанбаатар" чуулгын үйл ажиллагаа, бэлтгэл ажилд шаардлагатай зардлын асуудлыг судлаж 2007 оны төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/, Соёл урлагийн газар /Ц.Пүрэвхүү/-т тус тус даалгасугай.

Гурав. Тус чуулгыг орлогоороо зардлаа нөхөж, бие даан ажиллах хүртэл санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг судлаж, 2007 оны төсөвт тусгах арга хэмжээ авахыг Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2006 оны
10 сарын 26 ний өдрийн
530-р захирамжийн
нэгдүгээр хавсралт.

НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ЧУУЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Улаанбаатар чуулга / цаашид чуулга гэх / нь Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, иргэдийн уран сайхны боловсролыг дээшлүүлж, үндэсний болон сонгодог, орчин үеийн урлагийг түгээн дэлгэрүүлэх, Улаанбаатар хотыг гадаад, дотоодод сурталчлах зорилго бүхий мэргэжлийн урлагийн байгууллага мөн.

1.2. Чуулга нь зорилт үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомжууд төрөөс баримтлах соёлын бодлого, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, захирамж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллана.

1.3. Чуулгын дүрэм дотоод журмыг хамтран боловсруулж, чуулгын захиргааны зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэж чуулгын даргын тушаалаар баталж мөрдөнө.

1.4. Чуулга нь хуулийн этгээд болохын хувьд тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

Хоёр. Чуулгын удирлага зохион байгуулалт

2.1. Чуулгын бүтэц зохион байгуулалт орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, Чуулгын даргыг томилно.

2.2. Чуулгын санхүү, уран бүтээлийн удирдлагыг чуулгын даргын тушаалаар ажиллуулна.

2.3. Чуулгын захиргааны зөвлөл, уран сайхны зөвлөл нь чуулгын даргад санал оруулах эрхтэйгээр ажиллана.

2.4. Чуулгын хөдөлмөрийн дотоод журам, уран сайхны зөвлөлийн ажиллах журам, удирдах ажилтны ажлын байрны тодорхойлолтыг чуулгын дарга батална.

2.5. Чуулгын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн дангаараа буюу байгууллагын дарга захиралтай хамтран шийдвэр гаргаж биелэлтийг хангуулна.

2.6. Чуулгын урын сангийн бодлогын асуудлыг уран сайхны удирдагч хариуцна. Уран сайхны удирдагч нь тус театрын үйл ажиллагааны гол чиглэлд тохирох мэргэжлийн уран бүтээлч байна. Уран сайхны удирдагчийг чуулгын дарга томилно.

2.7. Чуулгын захиргаа, удирдах, дууны анги, хөгжим анги, тайз гэрэл, хувцас үйлчилгээний анги, маркетингийн албыг баталсан орон тоонд багтаан Чуулгын дарын тушаалаар баталгаажуулан ажиллана.

Гурав. Чуулгын үүрэг

3.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах

3.2. Соёл, урлагийн талаар холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах

3.3. Монгол Улсын Соёлын тухай хууль болон бусад хуулийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт соёл урлагийн үйл ажиллагаа явуулдаг байууллагуудтай өмчийн хэлбэр үл харгалзан хамтран ажиллах

3.3.1. Чуулга нь уран бүтээлчдээ мэргэжил арга зүйн удирлагаар хангаж, уран бүтээлийн чанарыг сайжруулах арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх

3.3.2. Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах

3.3.3. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай соёл урлагийг хөгжүүлэх талаар өргөн хүрээтэй хамтран ажиллах

3.4. Чуулга нь уран бүтээлчид ажилтнуудыг тогтвор сууршилтай, үр бүтээлтэй ажиллуулах, тэдний хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах, мэргэжил боловсролыг нь дээшлүүлэх мэргэжлийн суралт семинарт хамруулах

3.5. Үндэсний уламжлалт соёл урлаг, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, уламжлуулах сонгодог болон орчин үеийн урлагийг өндөр түвшинд туурвих

3.6. Чуулгын хэмжээнд сахилга дэг журам уран бүтээлчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажлын цаг ашиглалт хөгжмийн зэмсэг, тоглолтын хувцас, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллах

3.7. Нийслэл Улаанбаатар хотоо улс, олон улсын хэмжээнд тогтмол сурталчилах

Дөрөв. Чуулгын эрх

4.1. Уран бүтээл туурвих, стандартын шаардлагад нийцсэн байр тоног төхөөрөмж хөгжмийн зэмсэг, хувцас хэрэглэлээр хангагдах

4.2. Мэргэжлийн уран бүтээлчдийг сонгон шалгаруулж, ажилд томилох чөлөөлөхөд санал өгөх, тэдний ажлын талаар дүгнэлт гаргах

4.3. Чуулга нь эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжинд олгогдсон эрхийн дагуу гадаад орнуудын мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулан хэрэгжүүлэх

4.4. Чуулга нь Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагын үйлчилгээний хүрээг өргөжүүлж, олон нийтийг хамарсан соёл урлагийн уралдаан тэмцээн зохион байгуулах

4.5. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа соёл урлагын байгууллага, чөлөөт уран уран бүтээлчдийн зохион байгуулж байгаа үйл ажиллагаа уран бүтээлийн тайлан тоглолт соёл урлагийн арга хэмжээнд мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтарч ажиллах

4.6. Чуулга нь соёл урлагийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

4.7. Чуулга нь соёл урлагийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан уран бүтээлчид, ажилчдаа төр засгийн болон Нийслэлийн ИТХ, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналд тодорхойлох

Тав. Чуулгын уран сайхны зөвлөл

5.1. Чуулгад шинэ уран бүтээл сонгох, сэргээн бүтээх, уран сайхны бодлого явуулах, уран бүтээлчдэд мэргэжлийн үнэлгээ өгөх, шагналд тодорхойлох болон үйл ажиллагааны тулгамдсан асуудлаар ерөнхий захиралд танилцуулах үүрэг бүхий Уран сайхны Зөвлөл / УСЗ / ажиллуулна.

5.2. Уран сайхны Зөвлөлийн бүрэлдхүүнд нэр хүндтэй ахмад, залуу уран бүтээлчид, захиргаа, мэргэжлийн болон ангийн удирлага хамт олны саналыг үндэслэж оруулна. Зөвлөлийн бүрэлдхүүнийг чуулгын даргын тушаалаар батална.

5.3. Уран сайхны Зөвлөл нь чуулгын жилийн төсөв хөрөнгө оруулалт шинэ болон сэргээх уран бүтээлийн талаар төлөвлөх саналаа оруулах эрхтэй.

5.4. Уран сайхны Зөвлөл нь өөрийн үйл ажиллагаа зохиосон ажлын тайлан, уран бүтээлийн бодлогын талаар чуулгын даргад 7 хоног бүрт танилцуулна.

Зургаа . Захиргааны Зөвлөлийн хурал

6.1. Чуулгын Захиргааны зөвлөлийн гишүүдийн хурал нь чуулгын өмнө тавигдсан бүх зорилтыг ханган биелүүлэхэд бүрэн чиглэгдэнэ.

6.2. Чуулгын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ажилтны ажлын хариуцлага, аж ахуйн төсөв, хөрөнгө, төлөвлөгөөний биелэлт, үзвэрийн бодлого, харуул

манаа, ариун цэвэр, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт гэрэл цахилгаан холбоо дулааны ашиглалт, өдөр тутмын ажлын явцын талаар захиргааны зөвлөлийн хурлаар авч хэлэлцэнэ.

6.3. Чуулгын дарга захиргааны зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг биелүүлэхэд хяналт тавьж ажиллахна.

Долоо . Чуулгын хөрөнгө

7.1. Чуулгын зориулалтын байр тоног төхөөрөмжөө уран бүтээлд бүрэн ашиглана. Уран бүтээлийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор зал танхим тайзыг мэрэгжлийн уралдаан, тэмцээн, хурал уулзалт, ярилцлагад түрээслүүлж болно.

7.2. Чуулгын хөрөнгө эд хогшил дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Чуулгын сан хөмрөгт бүртгэгдсэн эд зүйл
- Чуулгын үндсэн хөрөнгөд тусгагдсан барилга тоног төхөөрөмж, бусад зүйл
- Байгууллага иргэдээс хандивласан эд зүйлс тоног төхөөрөмж, бусад зүйл

7.3. Чуулгын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Чуулгын үйл ажиллагааны орлого
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого
- Чуулгын үйл ажиллагааг дэмжсэн дотоод гадаадын аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандивласан хөрөнгө, хөнгөлөлтэй зээл

Найм. Чуулгын бичиг баримтын бүрдүүлэлт, архивын ажлын зохицуулалт

8.1. Чуулгын бичиг баримтын бүрдүүлэлт архивын ажлыг журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.2. Төрийн хүндэтгэлийн болон бусад концерт, соёлын өдрүүдийн найруулагчийн төлөвлөгөө, сценари – цомог хөтөлбөр, шинэ уран бүтээлийн тайз хувцасны загвар / эскиз /, хөгжим, бүжгийн цомнол, нот зэргийн нэг хувийг чуулгын урын санд хадгална. Зарим томоохон бүтээлийн холбогдох материалын нэг хувийг театрийн музейд шиилжүүлнэ.

8.3. Урын сан архив, театрийн музейд шиилжүүлэх баримт материал нь бүрэн цэгцлэгдсэн УСЗ-р батлагдсан байна.

8.4 Чуулгын захиргаа санхүү, уран бүтээлийн чиглэлээр шинээр гарч ирсэн болон тухайн жилд хэрэгжсэн бүх материалыг нэтгэн чуулгын архивт хадгална.

Ес. Бусад зүйл

9.1. Чуулгын үйл ажиллагааны бусад харилцааг чуулгын дотоод журам, уран бүтээлчид ажилтантай хийсэн "хөдөлмөрийн гэрээ"-гээр зохицуулна.

9.2. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

9.3. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.


**Нийслэлийн "Улаанбаатар" чуулгын орон тоо,
цалингийн сан**

№	Албан тушаал	Орон тоон ы хязга ар	Үндсэн цалин /олгох/	Унаа	Хоол	Бүгд	Бүгд	
							Сарын цалин /мян.төг/ г/	Жилийн цалин /мян.төг/
Захиргаа		12						
1	Дарга	1	188.2	8.8	11.0	19.8	208.0	2496.0
3	Хүний нөөцийн менежер	1	100.2	8.8	11.0	19.8	120.0	1440.0
4	Нарийн бичгийн дарга	1	80.2	8.8	11.0	19.8	100.0	1200.0
5	Нягтлан бодогч	1	105.2	8.8	11.0	19.8	125.0	1500.0
6	Касс, нярав	1	70.2	8.8	11.0	19.8	90.0	1080.0
7	Жолооч	1	65.2	8.8	11.0	19.8	85.0	1020.0
8	Жижүүр	3	60.2	8.8	11.0	19.8	240.0	2880.0
11	Цэвэрлэгээний үйлчлэлч	3	60.2	8.8	11.0	19.8	240.0	2880.0
Дүн								14496.0
Уран бүтээлийн алба		52						
1	Уран сайхны удирдагч	1	130.2	8.8	11.0	19.8	150.0	1800.0
2	Хөгжмийн удирдаач	1	110.2	8.8	11.0	19.8	130.0	1560.0
3	Найруулагч	1	115.2	8.8	11.0	19.8	135.0	1620.0
4	Хөгжмийн багш зохиолч	1	100.2	8.8	11.0	19.8	120.0	1440.0
5	Бүжгийн багш дэглээч	1	100.2	8.8	11.0	19.8	120.0	1440.0
6	Дууны багш, хормейстр	1	100.2	8.8	11.0	19.8	120.0	1440.0
7	Концертмейстр	1	90.2	8.8	11.0	19.8	110.0	1320.0
8	Хөгжимчид	21	110.2	8.8	11.0	19.8	2730.0	32760.0
9	Дуучид	8	80.2	8.8	11.0	19.8	800.0	9600.0
10	Бүжигчид	12	80.2	8.8	11.0	19.8	1200.0	14400.0
11	Хөөмийч	2	80.2	8.8	11.0	19.8	200.0	2400.0
12	Нугараач	2	80.2	8.8	11.0	19.8	200.0	2400.0
Дүн								72180.0
Менежмент, маркетингийн алба		3						
1	Ерөнхий менежер	1	100.2	8.8	11.0	19.8	120.0	1440.0
2	Реклам сурталчилгаа, борлуулалтын менежер	1	90.2	8.8	11.0	19.8	110.0	1320.0
3	Зохион байгуулагч	1	90.2	8.8	11.0	19.8	110.0	1320.0
Дүн								4080.0
Аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний алба		7						
1	Албаны дарга	1	100.2	8.8	11.0	19.8	120.0	1440.0
2	Зураач	1	95.2	8.8	11.0	19.8	115.0	1380.0
3	Оёдолчин, хувцасны эрхлэгч	1	70.2	8.8	11.0	19.8	90.0	1080.0
4	Тонмейстр	1	90.2	8.8	11.0	19.8	110.0	1320.0

5	Гэрэл, техникийн ажилтан	1	55.2	8.8	11.0	19.8	75.0	900.0
6	Тайз, жижиг хэрэглэлийн эрхлэгч	1	55.2	8.8	11.0	19.8	75.0	900.0
7	Гуталчин, мужаан	1	55.2	8.8	11.0	19.8	75.0	900.0
	Дүн							7920.0
	Үндсэн цалин бүгд							98676.0
	Уран бүтээлчид						500.0	6000.0
	Бүгд	74					8723.0	104676.0
/Чуулга байгуулагдахад нэг удаад гарах зардлыг хавсаргав/								

Нийслэлийн Засаг даргын 2006 оны
 19 дугаар сарын 26-ний өдрийн
 530/2006-р захирамжийн
 хоёрдугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН "УЛААНБААТАР" ЧУУЛГЫН
 БҮТЭЦ ОРОН ТОО**



- Захиргаа анги**
1. Чуулгын дарга
 2. Нягтлан бодогч
 3. Хүний нөөцийн менежер
 4. Даргын туслах
 5. Нярав

- Уран сайхны зөвлөл**
1. Уран сайхны удирдагч
 2. Хөгжмийн удирдаач
 3. Найруулагч
 4. Зураач
 5. Бүжгийн багш
 6. Дууны багш
 7. Маркетингийн албаны дарга

- Захиргааны зөвлөл**
1. Дарга
 2. Нягтлан бодогч
 3. Уран сайхны удирдагч
 4. Хүний нөөцийн менежер

Удирдах анги	- 7
Хөгжим анги	- 21
Дууны анги	- 8
Бүжгийн анги	- 12
Маркетингийн алба-3	
Тайз гэрлийн анги	- 3
Үйлдвэрийн анги	- 4
Үйлчилгээний анги	- 7
Нугараач	- 2
Хөөмийч	- 2
Бүгд	- 74